



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/785

Арвайхээр

Д.Нямсүрэнд буцалтгүй тусламж
олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалт, Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох” 7 дугаар тогтоолоор батлагдсан журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь;

1. Сант сумын Засаг даргын Тамгын газрын даргаар ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгох болсон тул Дүүмаа овогтой Нямсүрэнд 14.522.955 (арван дөрвөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун тавин тав) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Дээрх буцалтгүй тусламжийн 14.522.955 (арван дөрвөн сая таван зуун хорин хоёр мянга есөн зуун тавин тав) төгрөгийг орон нутгийн төсвийн тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101493